



**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

「 Баримт бичиг нягтлан шалгах комиссын
бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дугаар тушаалаар батлагдсан Байгууллагын архивын зааврын 1 дүгээр бүлгийн 1.3.2 дугаар заалт, 2 дугаар бүлгийн 2.2.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

ББНШК-ын дарга

Нарийн бичгийн дарга

Гишүүн

Спортын хөгжлийн хэлтсийн дарга

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Нийтийн биеийн тамирын хөгжлийн

хэлтсийн дарга

Ахлах мэргэжилтэн

Мэргэжилтнүүд

2. Тус хорооны баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтад баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэл ажлыг зохион байгуулан ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. ББНШК-ын ажлыг тогтмолжуулан үр дүнтэй ажиллахад хяналт тавьж ажиллахыг комиссын даргад даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500013

D:\2017\2017 tushaal\A tushaal "2017"\BBNSHK.docx